



МОНГОЛ УЛСЫН
БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ
САЙДЫН ТУШААЛ

2022 оны 04 сарын 01 өдөр

Дугаар А/115

Улаанбаатар хот

Гэрээний хугацаа сунгах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Дээд боловсролын санхүүжилт, суралцагчдын нийгмийн баталгааны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.7 дахь хэсэг, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.6 дахь хэсэг, Засгийн газрын 2021 оны 264 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан “Дээд боловсролын сургалтын байгууллагын суралцагчид төрөөс санхүүгийн дэмжлэг үзүүлэх журам”-ын 3 дугаар зүйлийн 3.2.6 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Батбаатар овогтой Болорын суралцсан сургуулийн нэхэмжлэл, суралцагчийн өргөдөл, хөдөлмөрийн чадвар алдалтын актыг харгалзан гэрээний хугацааг нэг жилээр сунгахыг Боловсролын зээлийн сан /Д.Гарди/-д зөвшөөрсүгэй.

2. Холбогдох журмын дагуу төлбөр тооцоо хийхийг Боловсролын зээлийн сан /Д.Гарди/-д, энэхүү тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Гадаад харилцаа, хамтын ажиллагааны газар /Ш.Нарантуяа/-т тус тус даалгасугай.

САЙД



Я.ЭНХ-АМГАЛАН

142210403